

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өлзийтийн Аравжир	Дугаар	L191
Оршин суугаа аймаг	Баян-Өлгий	Оршин суугаа сум	Алтанцөгц
Төрсөн газар	Алтанцөгц сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Алагийн хийд, Цагаан түнгийн хийд	Сүм хийдийн дугаар	БӨАЦ 077
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 7-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Билэг-Өрнөх



Баян-Өлгийн аймгийн Алтанцөгц сумын Цагаан түнгийн хийд, Алагийн хийд

Энэ хүн Алтанцөгцийн Цагаан түнгийн хүрээнд багадаа шавилж сууж байсан ийм хүн юм аа. За та хүрээнийхээ тухай товч ярина уу? Танай хүрээ хаана ямар нэртэй хүрээ байсан юм бэ?

Аравжир: Манай хүрээ Алагийн хүрээ нэртэй байсан юм. Баянхонгор уулын одоо манай энэ зуслан талаар харсан Алагийн хүрээ гэж байгуулагдсан байсан. Алагийн хүрээ байшинтай байгаад, тэгээд тэр Алагийн хүрээ гэж байсан газрын нэр, тэндээс нүүгээд Цагаан түнгийн Ховдын голын наана талд очоод дахиад заримыг нь гэртэй, заримыг нь байшинтай том их хүрээ сүм гэж байсан. Ламирангийн хүрээ гэж хоёр сүмтэй байсан юм. Тэгээд энэ хүрээ байж байгаад 1937 онд эсэргүү хэрэгтэн гээд лам нарыг бариад бариад явж билээ. Бариад явсны дараа бүх хийд нь эзгүй хоцорлоо. Тэнд Эвийн Жигмэд гэдэг хүн лам нарыг нь тэр хурал хурж байх үед цай хоол хийж өгдөг тийм мухар гартай лам байсан юм. За тэгээд лам нарыг баригдаад хөдөлгөөнд байхад чинь би хүрээнд байхад тийм байшинтай байлуу, тийм гэртэй байлуу. Миний байсан гэрийг Эвийн Жигмэд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гэдэг хүн мэддэг юм. Тэр хүнээр заалгаж аваад авчихсан гэж зааж өгчээ.Тэгээд Жигмэд гэдэг хүн цөмийг нь зааж өглөө. Булуу гэдэг байсан юм. Одоогийн Уаз шиг жижиг задгай машинаар очоод лам нарыг нь бүгдийг нь ачаад явчихсан. Бурхан тахил судар ном нь тэр чигээрээ хоцорсон.Тэр үед сумын намын үүрийн дарга байсан Аюурзаны Цангиа, эмч Дэлгэр гэж 2 хүн байсан. Тэр хоёр тэнд үлдсэн судар ном, тахилыг 15 тэмээнд ачаад Цэгтэй гэдэг газар нарийн хавчиг жалганд гурван газар булсан. Тэгээд судар ном, өлгөдөг бүрхдэг тийм мөнгөн тоног жаазтай нь шатаачихсан. Бүгдийг нь түлчихсэн, мөнгийг нь шатаад харлачихсан том том улаан шар шүрнүүд үлдчихсэн байсан. Тэгээд л манай нутгийн зарим хүмүүс шүрийг нь аваад халуун цайнд хийж буцалган өнгийг нь гаргаж бэлзэг хийж байдаг л байсан.

Билэг-Өрнөх: Танай хүрээ энэ бусад өөр ямар хүрээ хийдтэй холбоотой байсан бэ?

Аравжир: Алтайн хүрээтэй холбоотой байсан.

Билэг-Өрнөх: Алтайн хүрээ гэж аль хүрээг хэлж байна вэ?

Аравжир: Дээр үед Алтай, Буянт гэж хоёр сум байсан. Одоо Алтай сум нь байна. Алтай сумын тэнд байсан юм.

Билэг-Өрнөх: Танай хүрээ шарын шашны чиглэлийн үү, улааны шашны чиглэлийн үү? Аль чиглэлийн хүрээ байсан бэ?

Аравжир: Шарын шашны чиглэлийн хүрээ байсан.

Билэг-Өрнөх: Өдөрт ямар уншлагатай байсан бэ?

Аравжир: Одоо Ганданд уншиж буй бүх номыг хурна. Ганжуур гэж их том ном байлаа. Зочид хурна, 7 сард хоног ном уншихдаа одоо Үрэл гэж нэрлэдэг юм. Тогоон дотор жижиг жижиг гурил хийж байгаад улаан шунхаар будчихдаг юм. Тэгээд ширмэн тогоон дотор хийгээд таглачихаад ном уншина.Ингээд маань дуусахад тэр үрэлнүүд өсөж одоогийн төмс шиг болно.Тэгээд л хуралд ирсэн хөдөөний хүмүүс ирж үрэл зална.Тэр үед эмэгтэйчүүдийн хүзүүнд мөнгөөр тоноглож хийсэн гуу гэж юм байсан.Гуун дотор нь хөвөнд боогоод хийчихнэ. Өвчин зовлон ороох, нүд өвдөх, хоолой өвдөх зэрэгт нөгөө үрлээсээ жаахан хүртчихэд өвчин дороо намдана. Гуу гэж тийм мөнгөн нугастай, задалж болдог, хүзүүндээ зүүдэг сав байсан юм.

Билэг-Өрнөх: Шавь банди нараа одоо яаж ном сургаж байв?

Аравжир: Шавь нараа хажуудаа суулгаж үсэг заана.Бичүүлэхгүй, ерөөсөө дандаа нүдлүүлж цээжлүүлнэ. Энд Лхавжаа овоо гэж овоо байсан. Үсгээ нүдэлсэн банди нар Лхавжаа овоонд очиж том лам нарт шалгалт өгөөд гэцэл болно. Чойг гэж юм байна. Түүнийг нэг хоёр давхар шар даалимбаар оёчихсон.Түүнийг их лам нар өмсчихөөд номоо сурсан банди нарт гэцэл сахил хүртээнэ.Лам нараа айлуудаар хуваарилаад тараачихна. Тэгээд лам нар явж айлуудад ном уншаад хүмүүсийн өгсөн өргөл барьцыг их жасаанд авчирч тушаана. Их жасааны нярав Гэндэн гэж хүн байлаа. Тэгээд тэр Гэндэн гэдэг хүн бүх лам нарын өргөл барьцыг хурааж байгаад жилийн эцсээр тэр хураасан юмыг нь зэд гэж нэрлээд том лам нар, дунд лам нар гэцлүүдэд хуваана. Голдуу цай, даалимба байдаг.Миний ах Сунруу , Намдаг гээд хоёр хүн хүрээнд сууж байлаа. Тэгээд гурван хүнд хуваахад гурван шүүдай цай даалимба оногдоно.

Билэг-Өрнөх: Хүрээ малтай байсан үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Аравжир: Өө тэмээ малтай байсан. Хөх дархан Мөнх гэдэг хүн маллаж байлаа, малыг нь. Хөх дархан гэдэг бол овог нь биш, тэр өөрөө дархан хүн байсан юм.